



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 411

Улаанбаатар хот

**Орон сууц хувьчлах товчоо
байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Орон сууц хувьчлах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 67 дугаар тогтоолоор баталсан “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”-ын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баян-Өлгий аймгийн орон сууц хувьчлах товчоог хавсралтад заасан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2.Орон сууц хувьчлах тухай хууль тогтоомж, “Орон сууц хувьчлах товчооны ажиллах журам”-ыг мөрдөж ажиллахыг товчоонд үүрэг болгосугай.

3.Товчооны үйл ажиллагааны зардлыг зохих журмын дагуу тооцож, төсөвт тусган санхүүжүүлэхийг Баян-Өлгий аймгийн Засаг дарга А.Гылымханд зөвлөсүгэй.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



З.МЭНДСАЙХАН

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2019 оны 10 дугаар сарын 29-ний
өдрийн 441 дугаар тогтоолын хавсралт



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ОРОН СУУЦ ХУВЬЧЛАХ
ТОВЧООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Товчооны дарга

Аймгийн Засаг дарга

Нарийн бичгийн дарга

Орон нутгийн өмчийн газрын өмч хариуцсан
ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын дарга

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын барилгын
техникийн улсын байцаагч

----- о О о -----